



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот


Г Хөтөлбөр шинэчлэн батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2.118 дугаар зорилтын 7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зам, тээврийн салбарын стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл, норм, норматив, техникийн баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Мэргэн/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 121 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2019 оны 05 дугаар сарын 23 өдрийн  
161 дугаар тушаалын хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ,  
ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛ, НОРМ, НОРМАТИВ,  
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОOG  
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Авто замын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хуулийг тус тус үндэслэн Зам, тээврийн сайдын 2013 оны 85 дугаар тушаалаар “Зам, тээврийн салбарын стандартыг шинэчлэн боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2013-2016 онд хэрэгжүүлсэн бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 121 дүгээр тушаалаар “Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хугацаа (2013-2019 онд)-нд зам, тээврийн салбарын нийт 270 гаруй стандартыг боловсруулж батлуулжээ.

Зам, тээврийн салбарын үндэсний стандарт, норм, техникийн баримт бичгийг худалдан авах, орчуулах, боловсруулах ажлыг дунджаар 1-3 жилд багтаан Зөвлөх компаниудаар гүйцэтгүүлж ирсэн бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг тус яамны “Зам, тээврийн салбарын баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган, тус сангийн Удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлж ирсэн болно. Уг сангаас 2015-2017 онуудад 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг салбарын стандарт, норм, техникийн баримт бичиг, судалгааны ажил боловсруулахад зарцуулжээ. Авто замын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 90 дүгээр тушаалаар “Зам, тээврийн салбарын баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-г “Авто замын норм нормативын сан” болгон өөрчилж, уг сангийн чиг үүргийг тус яамнаас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т шилжүүлсэн. Цаашид Авто замын тухай хуулинд нийцүүлэн салбарын стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн тогтолцоог өөрчлөн сайжруулах асуудал тулгамдаж байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль 2017 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 97 дугаар захирамжийг үндэслэн зам, тээврийн салбарын стандартын улсын үзлэгийг 2018 оны 3 улиралд зохион байгуулсан билээ. Уг ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 146 дугаар тушаалаар байгуулсан салбар комисс нь авто замын 255, автотээврийн 112, төмөр зам, далайн тээврийн 151, иргэний нисэхийн 27, нийт 545 үндэсний стандартад үзлэг хийсэн

байна. Энэхүү үзлэгийн дүн, тайланг үндэслэн зам, тээврийн салбарын стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох ажлыг үе шаттайгаар хийх, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой “заавал мөрдөх” зохицуулалттай байсан салбарын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулинд нийцүүлэн техникийн зохицуулалтад шилжүүлэх шаардлагатай болоод байна. Түүнчлэн Хэмжил зүйн тухай хууль 2019 онд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан салбарын хэмжил зүйн асуудлыг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар болсон.

Иймд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль болон Авто замын тухай хууль шинэчлэгдэж эрх зүйн орчин өөрчлөгдсөн, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 2.118 дугаар зорилтын 7 дахь заалт, Стандартын улсын үзлэгийн дүн, тайлан нь энэхүү хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах үндэслэл болж байна.

#### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Монгол Улсын зам, тээврийн салбарт стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл, хэмжил зүй, норм, норматив, техникийн баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт хүргэж, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

- 2.2.1. Стандартчилал, техникийн зохицуулалт;
- 2.2.2. Тохирлын үнэлгээний итгэмжлэл;
- 2.2.3. Норм, норматив, техникийн баримт бичиг.

#### Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг үндэслэхээс гадна дараах зарчмыг баримтална:

- 3.1.1. судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 3.1.2. олон улсын жишигт хүргэх.

#### Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Стандартчилал, техникийн зохицуулалт зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. зам, тээврийн салбарын үндэсний болон байгууллагын стандартыг боловсруулах, үзлэг хийх, сурталчлах, сургалт зохион байгуулах, стандартчиллын техникийн хороодын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;

4.1.2. зам, тээврийн салбарт хамаарах Нэгдсэн үндэстний байгууллагын Европын Эдийн засгийн комисс (UNECE), Олон улсын стандартчиллын байгууллага (ISO), Европын холбоо (CEN), Америкийн стандартчиллын байгууллага (AASHTO, ASTM) бус нутгийн болон бусад дэвшилтэт стандарт, техникийн зохицуулалтыг нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах;

4.1.3. хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлын асуудлаар зам, тээврийн салбарт хамаарах техникийн зохицуулалтыг шинээр боловсруулж, батлан мөрдүүлж, хэрэгжилтэнд хяналт тавих.

4.2. Тохирлын үнэлгээний итгэмжлэл зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын сорилт, туршилтын лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын тохирлын үнэлгээний итгэмжлэлд хамруулах;

4.2.2. салбарын тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг бий болгох.

4.3. Норм, норматив, техникийн баримт бичиг зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. зам, тээврийн салбарын стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн сангийн асуудлыг холбогдох хуулиудад тусгах, хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

4.3.2. салбарын норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулж, батлан мөрдүүлэх, хэвлэн сурталчлах, сургалт зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах.

#### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2019-2025 онд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил тутам боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

5.3. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.3.1. улсын болон орон нутгийн төсвийн төсөв;

- 5.3.2. норм, норматив, техникийн баримт бичгийн сангийн хөрөнгө;
- 5.3.3. олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж;
- 5.3.4. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
- 5.3.5. бусад эх үүсвэр.

**Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

6.1. Хөтөлбөр, түүний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулах ажлыг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Стандарт, нормативын нэгж хариуцан ажиллана.

6.2. Энэхүү хөтөлбөрийн 6.1 дэх хэсэгт заасан ажлыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, зам, тээврийн салбарын стандартчиллын техникийн хороод (TX15, TX15/DX01, TX33, TX34), хэмжил зүй, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн техникийн хороодын хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

**Долоо. Хөтөлбөрийн үр дүн**

**7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:**

7.1.1. зам, тээврийн стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгосноор зам, тээврийн салбарын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдна;

7.1.2. зам, тээврийн салбарт 3-аас доoshгүй техникийн зохицуулалтын баримт бичигтэй болсон байна;

7.1.3. зам, тээврийн салбарт тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагын тоо 3-оос доoshгүй нэмэгдсэн байна;

7.1.4. зам, тээврийн салбарын 2018 оны стандартын улсын үзлэгийн дүн, тайланд тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна.

**Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан жил тутам хяналт шинжилгээ хийнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд зохих журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.